

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 09 сарын 10-ны өдөр

№ 17

Улаанбаатар хот

Тогтвортой хөгжлийн санг байгуулах, зарцуулах журам батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн холбогдох заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн Тогтвортой хөгжлийн санг байгуулах, зарцуулах журмыг 1 дүгээр Хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 09 сарын 10-ны өдөр

№ 18

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (Цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.20 дахь заалт, Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журмын 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсгийг тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компани нь “Хайпэй” ХХК-тай мини апп хөгжүүлэлт хийх зорилгоор “Хамтран ажиллах гэрээ” буюу сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1-д дурдсан эрх хэмжээний хүрээнд сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б.НАРАНБАТ

